



**Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2022 оны ээлжит 04 дүгээр хуралдааны  
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны ээлжит 04 дүгээр хуралдааныг 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр холимог оролцоотой (биеэр болон цахим) зохион байгуулав.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны ээлжит 04 дүгээр хуралдаанд "Хөдөлгөөнт холбооны 5G сүлжээний радио давтамжийн хуваарилалт ба зохицуулалт" баримт бичгийн төслийн танилцуулга (анхны хэлэлцүүлэг); Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2021 оны жилийн эцсийн статистик, үндсэн үзүүлэлтийн талаар танилцуулга; Бусад: -Хөрөнгө оруулалт-2022 он: "Үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээний ачаалал, чанарын хэмжилтийн систем" төслийн систем ба тоног төхөөрөмжийн үзүүлэлт, хэрэгжүүлэх хуваарь, төлөвлөгөөний тухай танилцуулга; (Хорооны 2022 оны ээлжит 01 дүгээр хуралдаан); -Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай (Хорооны 2021 оны 53 тоот тогтоол); -"Хорооны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн аудит"-ийн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх тухай" (Тэмдэглэлийн эцсийн найруулгын төсөл); Тусгай тусгай зөвшөөрлийн талаар үнэлгээ, дүгнэлтийн тухай (Тусгай зөвшөөрөл олгох тухай, тусгай зөвшөөрөл сэргээх, шилжүүлэх, хүчингүй болгох тухай) зэрэг 6 асуудлыг тус тус хэлэлцэж, зохицуулах хорооны 5 тогтоолыг баталж, тус хуралдааны 1 тэмдэглэлээр бүтцийн нэгжийн удирдлагад хугацаатай үүрэг даалгавар, удирдамж чиглэлийг өгөхөөр шийдвэрлэв.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Радио долгионы тухай хуулийн 5<sup>1.1.2</sup>, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.5 дах заалт, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны А/45 дугаар тушаалаар батлагдсан "Монгол Улсад Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэл"-ийг тус тус үндэслэн "Хөдөлгөөнт холбооны 5 дах үеийн технологи, сүлжээнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, зохицуулалт ба техникийн нөхцөл шаардлага"-ыг хуулиар олгосон бүрэн эрхийн хэмжээнд тогтоож батлах, хэрэгжилтийг хангуулах шаардлага үүсэж байна. Баримт бичгийн төслийг боловсруулахдаа дээрх хуулийн тогтоомжийг баримтлахаас гадна хөдөлгөөнт холбооны 5 дах үеийн технологид ашиглах радио давтамжийн зурвасыг хуваарилахдаа ОУЦХБ (ITU)-ын шийдвэр, зөвлөмж, Дэлхийн радио холбооны дүрэм, үндэсний радио давтамжийн хүснэгт болон олон улсын стандартчиллын 3GPP байгууллагаас баталсан стандартыг үндэслэн ОУЦХБ-ын радио давтамжийн нэгдүгээр бүсэд зөвшөөрөгдсөн зурвасыг ашиглана. Тус хуралдаанд РДХЗГ, ажлын хэсгээс боловсруулсан "Хөдөлгөөнт холбооны 5G сүлжээний радио давтамжийн хуваарилалт ба зохицуулалт" баримт бичгийн төслийн танилцуулга (анхны хэлэлцүүлэг), уулзалт хэлэлцүүлгийн үр дүн, саналын товчоог тус тус авч хэлэлцээд, хуралдааны үеэр дарга болон гишүүдээс уг баримт бичгийн төслийн нэр бүхий тодорхой зүйл, заалтууд болон хөдөлгөөнт холбооны 5 дах үеийн технологийг нэвтрүүлэхдээ радио давтамжийн хуваарилалтын асуудлаас гадна үүрэн холбооны 5 дах үеийн сүлжээ, үйлчилгээ, үнэ тарифын зохицуулалтын арга хэмжээ, дүрэм журмын боловсруулалтын уялдааг хангах, иж бүрэн цогцоор авч үзэх

чиглэлээр өгсөн удирдамж, чиглэлийг цаашид баримтлан ажиллах, зохицуулалтад оролцогч болон эрх ашиг нь хөндөгдсөн хуулийн этгээд, үйлчилгээ эрхлэгч, хэрэглэгчдийн төлөөллийн санал зөвлөмжийг тусгаж, дараагийн ээлжит хорооны хуралдаанд хэлэлцүүлэхийг РДХЗГ /З.Амгалан/-т үүрэг болгов.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны ээлжит 04 дүгээр хуралдаанаар Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2021 оны жилийн эцсийн статистик, үндсэн үзүүлэлтийн талаар танилцуулга; “Хорооны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн аудит”-ийн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх тухай асуудлыг тус тус сонсов.

Бусад асуудлын хүрээнд, тус хуралдаанаар байгууллагын 2022 оны хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийн талаар зохицуулах хорооны 2021 оны 24 дугаар тэмдэглэлээр өгсөн удирдамж чиглэл, 2022 оны ээлжит 01 дүгээр хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд ЗБХГ, ажлын хэсгээс “Үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээний ачаалал, чанарын хэмжилтийн систем” төслийн систем ба тоног төхөөрөмжийн үзүүлэлт, хэрэгжүүлэх хуваарь, төлөвлөгөөний тухай танилцуулгыг хийлээ. Энэхүү асуудлыг хэлэлцсэн асуудлаар “Хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийн талаар авах арга хэмжээний тухай” 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 05 дугаар хуралдааны тэмдэглэлээр хуралдааны явцад хорооны дарга, гишүүдээс төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, цаашид анхаарах асуудлууд, холбогдох арга хэмжээг авч ажиллаж, хорооны хуралдаанд танилцуулахыг Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газар /Б.Мягмарнаран/-т үүрэг болгов.

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Захиргааны ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 16 тоот “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” тогтоолыг баталж, 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 53 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт оруулсан болно.

Хорооны 2022 оны ээлжит 04 дүгээр хуралдаанаар “Тусгай зөвшөөрөл олгох тухай”, “Тусгай зөвшөөрөл сэргээх тухай”, “Тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай”; “Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 4 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 4 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 12 тоот тогтоолын хавсралтаар 18 хуулийн этгээдэд 21 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.3 дах хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.6 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 13 тоот тогтоолоор 15 хуулийн этгээдэд 15 тусгай зөвшөөрлийг сэргээсэн;
- Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 5 дугаар зүйлийн

5.6, 5.7 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдэд 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн;

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дах заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 15 тоот тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгов.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо  
2022-05-09